

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын тамгын газрын  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/098/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Audit.mn  
Хэнтий аймаг  
Чингис хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан  
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	9
<b>3.1 Төлбөрийн акт</b> .....	9
<b>3.2 Албан шаардлага</b> .....	9
<b>3.3 Зөвлөмж</b> .....	9
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	10

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

---



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас 70-56-21-12, Факс 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2025.08.24 № 257

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Х.БААСАНСҮРЭН  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,178,040.9 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 1,100,719.9 мянган төгрөгийг зарцуулж, 77,321.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тус байгууллага нь тайлант онд наадмын талбай, бэлчээрийн худаг, ногоон байгууламж, ковш, цагдаагийн автомашиныг сумын ОНХС-ийн хөрөнгөөр, соёлын төвийн хуучин барилга, "Шинэ хөдөө" төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар трактор зэргийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар 7,700.8 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулж, албан хаагчдад олгосон урамшууллаас 3,202.2 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй, төрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлсний орлогын 40 хувь 1,580.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

232520257

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 12 зорилтын хүрээнд 170 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэл 91 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>137,718,871.00</b>	<b>147,165,768.00</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	812,720.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	812,720.00	-
3121	Төгрөг	812,720.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	812,720.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>28,436,470.00</b>	<b>18,445,987.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	352,324.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>28,436,470.00</b>	<b>18,093,663.00</b>
3352	Хувь хүмүүсээс авах авлага	28,436,470.00	18,093,663.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>77,169,681.00</b>	<b>124,719,781.00</b>
351	Түүхий эд материал	-	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>66,999,681.00</b>	<b>116,899,781.00</b>
35410	Бичиг хэргийн материал	540,000.00	640,000.00
35420	Аж ахуйн материал	66,459,680.00	112,599,780.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	3,660,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1.00	1.00
35600	Мал амьтад	10,170,000.00	7,820,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>31,300,000.00</b>	<b>4,000,000.00</b>
36300	Тэжээлийн нөөц	31,300,000.00	4,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,891,859,651.35</b>	<b>2,964,934,843.85</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,891,859,651.35</b>	<b>2,964,934,843.85</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,402,531,651.35</b>	<b>2,473,680,843.85</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,526,175,714.27	2,058,261,355.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(557,540,337.94)	(708,645,835.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	321,331,721.00	745,848,321.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(140,542,782.90)	(203,497,193.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	250,456,360.00	284,804,821.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(161,455,285.56)	(180,851,515.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,376,824.00	29,376,824.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,431,306.56)	(21,320,454.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	260,180,104.00	638,928,370.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(108,019,358.96)	(169,223,848.94)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>489,328,000.00</b>	<b>491,254,000.00</b>
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	489,328,000.00	491,254,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,029,578,522.35</b>	<b>3,112,100,611.85</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,029,578,522.35</b>	<b>3,112,100,611.85</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,029,578,522.35</b>	<b>3,112,100,611.85</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	361,691,461.29	361,691,461.29
51101	Өмч: - төрийн	361,691,461.29	361,691,461.29
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,496,672,288.83</b>	<b>2,579,194,378.33</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,496,672,288.83	1,504,373,067.19
51220	Тайланг үеийн үр дүн	-	1,074,821,311.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171,214,772.23	171,214,772.23
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,029,578,522.35</b>	<b>3,112,100,611.85</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,454,703,956.00</b>	<b>2,924,761,998.07</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>650,646,500.00</b>	<b>1,552,086,897.07</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>650,646,500.00</b>	<b>1,552,086,897.07</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	650,646,500.00	1,552,086,897.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	812,500.00	300,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	648,634,000.00	1,551,786,897.07
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>804,057,456.00</b>	<b>1,372,675,101.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>71,313,656.00</b>	<b>194,934,201.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,313,656.00	190,984,201.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,950,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	732,743,800.00	1,177,740,900.00
<b>132001</b>	<b>Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/</b>	<b>732,743,800.00</b>	<b>1,177,740,900.00</b>
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>992,961,984.72</b>	<b>1,687,014,058.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>992,961,984.72</b>	<b>1,587,968,175.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>981,299,546.68</b>	<b>1,424,812,434.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>355,071,673.00</b>	<b>597,702,375.00</b>
<b>210101</b>	<b>Үндсэн цалин</b>	<b>355,071,673.00</b>	<b>597,702,375.00</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,742,021.13</b>	<b>75,252,213.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,306,277.72	49,813,770.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,968,908.54	4,346,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,587,197.00	6,260,004.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,757,269.87	1,745,869.02
210205	Эрүүл мэндийн даатгал	8,122,368.00	13,085,869.25
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,052,604.42</b>	<b>84,023,402.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,474,646.42	35,745,942.80
210302	Тулш, халаалт	33,577,858.00	48,277,460.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>84,173,920.00</b>	<b>71,376,103.00</b>
210401	Бичиг хэрэг	8,222,400.00	5,592,000.00
210402	Тээвэр, шатахуун	70,077,020.00	61,361,603.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,012,000.00	2,922,500.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,500,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	535,500.00	-
210408	Бараа материал акталсны зардал	2,327,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,604,000.00</b>	<b>740,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,604,000.00	740,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,956,200.00</b>	<b>17,242,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,956,200.00	3,892,500.00
210602	Тавилга	-	1,250,000.00
210604	Урсгал засвар	-	12,100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,048,000.00</b>	<b>20,652,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,048,000.00	20,652,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33,993,731.00</b>	<b>56,892,236.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,944,778.00	53,546,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	930,000.00	1,014,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	397,800.00	470,448.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	164,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	570,000.00	725,000.00
210807	Газрын төлбөр	987,153.00	959,688.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>382,657,497.13</b>	<b>500,931,604.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,681,018.41	190,920,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	280,000.00	3,761,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	265,696,478.72	306,250,554.63
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,662,438.04</b>	<b>163,155,741.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,166,000.00</b>	<b>85,829,700.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	134,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	33,081,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмж	00.00	45,222,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,166,000.00	7,391,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, сэтгүүл	00.00	77,326,041.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		77,321,041.20
213405	Нэмэлт данснаас төвлөрүүлэх шилжүүлэг		5,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,496,438.04	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,496,438.04	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>99,045,883.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	99,045,883.00
223001	Бусад хөрөнгө	00.00	99,045,883.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>461,741,971.28</b>	<b>1,237,747,939.44</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,941,702.40</b>	<b>162,926,628.30</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,501,702.40	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,440,000.00	162,926,628.30
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-20,941,702.40</b>	<b>-162,926,628.30</b>
<b>Б</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>440,800,268.88</b>	<b>1,074,821,311.14</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>806,069,956.00</b>	<b>1,372,975,101.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,012,600.00</b>	<b>300,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,012,600.00</b>	<b>300,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,012,600.00	300,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	812,600.00	300,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>804,067,466.00</b>	<b>1,372,675,101.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>71,313,666.00</b>	<b>194,934,201.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс до	71,313,666.00	190,984,201.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий бо	-	3,950,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>732,743,800.00</b>	<b>1,177,740,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байг	732,743,800.00	1,177,740,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>806,267,466.00</b>	<b>1,273,929,218.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>806,267,466.00</b>	<b>1,273,929,218.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>774,678,647.96</b>	<b>1,092,679,813.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>365,005,964.00</b>	<b>697,877,092.00</b>
210101	Үндсэн цалин	217,315,713.00	337,033,761.00
210102	Нэмэгдэл	121,836,107.00	224,033,479.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,962,088.00
210104	Урамшуулал	4,027,994.00	15,847,764.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,826,150.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,807,730.13</b>	<b>75,429,820.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,492,430.13	48,988,020.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,824,000.00	6,655,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,064,300.00	3,327,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	765,900.00	3,327,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,661,100.00	13,132,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,214,604.42</b>	<b>84,023,402.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,009,646.42	35,745,942.80
210302	Түлш, халаалт	36,204,858.00	48,277,460.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,490,120.00</b>	<b>46,378,069.00</b>
210401	Бичиг хэрэг	3,160,400.00	5,097,000.00
210402	Тээвэр, шатахуун	26,483,220.00	33,949,159.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,910,000.00	2,922,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,936,500.00	2,589,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,580,000.00</b>	<b>1,800,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,580,000.00	1,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,427,200.00</b>	<b>31,663,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,802,200.00	12,635,400.00
210602	Тавилга	-	1,888,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	625,000.00	940,000.00
210604	Урсгал засвар	-	16,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,956,000.00</b>	<b>20,662,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	17,956,000.00	20,662,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам</b>	<b>97,867,911.00</b>	<b>76,778,866.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө	94,818,958.00	73,433,419.00
210803	Даатгалын үйлчилгээ	930,000.00	1,014,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	397,800.00	470,448.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	164,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	570,000.00	725,000.00
210807	Газрын төлбөр	987,153.00	959,688.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>143,329,118.41</b>	<b>169,077,185.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	141,536,118.41	157,535,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,793,000.00	1,542,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,678,908.04</b>	<b>181,249,404.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,646,000.00</b>	<b>86,829,700.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	-	944,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,081,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан ха	-	45,222,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,646,000.00	6,581,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаа</b>	<b>-</b>	<b>96,419,704.20</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	77,321,041.20
213405	Нэмэлт данснаас төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,098,663.00
<b>2136</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,932,908.04</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,932,908.04	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>812,600.00</b>	<b>99,046,883.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (6)</b>	<b>-</b>	<b>99,046,883.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>99,046,883.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>99,046,883.00</b>
223001	Бусад хөрөнгө	-	99,046,883.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН</b>	<b>-</b>	<b>(99,046,883.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>812,600.00</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>812,720.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>812,720.00</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>361,691,461.29</b>	<b>171,214,772.23</b>	<b>1,496,672,288.83</b>	<b>2,029,578,522.35</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	361,691,461.29	171,214,772.23	1,496,672,288.83	2,029,578,522.35
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>361,691,461.29</b>	<b>171,214,772.23</b>	<b>1,496,672,288.83</b>	<b>2,029,578,522.35</b>
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>361,691,461.29</b>	<b>171,214,772.23</b>	<b>1,496,672,288.83</b>	<b>2,029,578,522.35</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,700,778.36	7,700,778.36
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	361,691,461.29	171,214,772.23	1,504,373,067.19	2,037,279,300.71
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,074,821,311.14	1,074,821,311.14
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>361,691,461.29</b>	<b>171,214,772.23</b>	<b>2,579,194,378.33</b>	<b>3,112,100,611.85</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БАЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,178,040,900.00</b>	<b>1,100,719,858.80</b>	<b>77,321,041.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,178,040,900.00</b>	<b>1,100,719,858.80</b>	<b>77,321,041.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,092,123,100.00</b>	<b>1,014,890,158.80</b>	<b>77,232,941.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>650,511,400.00</b>	<b>597,877,092.00</b>	<b>52,634,308.00</b>
210101	Үндсэн цалин	414,687,400.00	337,033,761.00	77,653,639.00
210102	Нэмэгдэл	150,000,000.00	224,033,479.00	-74,033,479.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,824,000.00	20,962,088.00	-7,138,088.00
210104	Урамшуулал	00.00	15,847,764.00	-15,847,764.00
210105	Гэрээт ажлын хөлс	72,000,000.00	00.00	72,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шилжүүлэг</b>	<b>83,189,000.00</b>	<b>75,429,820.00</b>	<b>7,759,180.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	56,568,500.00	48,988,020.00	7,580,480.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,655,100.00	6,655,000.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,327,600.00	3,327,500.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,327,600.00	3,327,300.00	300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,310,200.00	13,132,000.00	178,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>86,442,100.00</b>	<b>84,023,402.80</b>	<b>2,418,697.20</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,775,000.00	35,745,942.80	(970,942.80)
210302	Түлц, халаалт	51,667,100.00	48,277,460.00	3,389,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,944,500.00</b>	<b>43,941,899.00</b>	<b>2,601.00</b>
210401	Бичиг хэрэг	4,114,200.00	5,097,000.00	(982,800.00)
210402	Тээвэр, шатахуун	31,000,000.00	32,512,999.00	(1,512,999.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,978,200.00	2,922,500.00	3,055,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	1,045,000.00	820,000.00	225,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,807,100.00	2,589,400.00	(782,300.00)
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,807,100.00</b>	<b>1,800,000.00</b>	<b>7,100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807,100.00	1,800,000.00	7,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>31,749,000.00</b>	<b>31,663,400.00</b>	<b>85,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,605,900.00	12,635,400.00	(6,029,500.00)
210602	Тавилга	8,000,000.00	1,888,000.00	6,112,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	940,000.00	3,100.00
210604	Урсгал засвар	16,200,000.00	16,200,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>21,500,000.00</b>	<b>20,652,000.00</b>	<b>848,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	21,500,000.00	20,652,000.00	848,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тусламж</b>	<b>84,882,200.00</b>	<b>76,778,855.00</b>	<b>8,103,345.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	80,759,200.00	73,433,419.00	7,325,781.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,800.00	00.00	622,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,014,300.00	1,014,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	470,448.00	65,952.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.00	176,000.00	69,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,400.00	725,000.00	15,400.00
210807	Газрын төлбөр	963,500.00	959,688.00	3,812.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>88,097,800.00</b>	<b>82,723,690.00</b>	<b>5,374,110.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,548,900.00	81,181,690.00	5,367,210.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,548,900.00	1,542,000.00	6,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>85,917,800.00</b>	<b>85,829,700.00</b>	<b>88,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>85,917,800.00</b>	<b>85,829,700.00</b>	<b>88,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшил	1,032,600.00	944,500.00	88,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	33,081,700.00	33,081,700.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажил	45,222,000.00	45,222,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, цагнал урамшуулал	6,581,500.00	6,581,500.00	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,178,040,900.00</b>	<b>1,100,719,858.80</b>	<b>77,321,041.20</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,177,740,900.00</b>	<b>1,100,419,858.80</b>	<b>77,321,041.20</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,177,740,900.00	1,100,419,858.80	77,321,041.20
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,000.00	300,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	300,000.00	0.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>194,934,201.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>77,789,655.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>77,789,655.00</b>
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогмол зардал	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,436,160.00
210402	Тээвэр, шатахуун	1,436,160.00
2105	Нормативт зардал	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-
2107	Томилолт, зочны зардал	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,353,495.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,353,495.00
211	ХҮҮ	-
212	ТАТААС	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,098,663.00
213405	Нэмэлт данснаас төвлөрүллэх шилжүүлэг	18,098,663.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>99,045,883.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	99,045,883.00
223001	Бусад хөрөнгө	99,045,883.00
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-</b>
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>194,934,201.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>194,934,201.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	190,984,201.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,950,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар санхүүгийн тайланд алдаа<sup>1</sup> 7,700,8 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг санхүүгийн тайлангийн аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн элэгдлын зардал нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 7,700.8 мянган төгрөгөөр зөрүүтэй

Аудитаар 4,782.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 2 төлбөрийн акт тогтоов.

#### 3.1 Төлбөрийн акт

- Төрийн захиргааны албанд тогтвор сууршилтай ажилласны урамшууллаас 3,202.2 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Төрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлсэн орлогын 40% болох 1,580.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

#### 3.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлийн зардал зөрүүтэй тооцсон	1	7,700,8			1	7,700,8	1	7,700,8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7,700,8</b>			<b>1</b>	<b>7,700,8</b>	<b>1</b>	<b>7,700,8</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшууллаас татвар суутгаагүй	1	3,202.2	1	3,202.2								
Түрээсийн орлогын 40%-г төсөвт төвлөрүүлээгүй	1	1,580.0	1	1,580.0								
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4,782.2</b>	<b>2</b>	<b>4,782.2</b>								

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
								-
								-
<b>Дүн</b>								-
<b>Нийт дүн</b>								-

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 16-ХЭА-2025/098/НА-СТА-ТШЗ  
А 2360453

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 3,202.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1."энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэж заасныг зөрчсөн байна.



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй;" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй татварын 3,202.2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Норовлин сумын Засаг даргын тамгын газрын дарга Х.Баасансүрэн, нягтлан бодогч Л.Энхдорж нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН

232550018



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 15-ХЭА-2025/098/НА-СТА-ТШЗ  
А 2360453 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос 1,580.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.2 -д "Төрийн болон орон нутгийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөвт төвлөрүүлээгүй 1,580.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга Х.Баасансүрэн, нягтлан бодогч Л.Энхдорж нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН

232550015